



“МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ (2024-2035) ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТААМАГЛАЛЫГ ШИНЭЧЛЭХ”

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2025.01.28

ХНХСҮСИ-ийн ЭША У.Мөнхзаяа




- 1 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
- 2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ
- 3 СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТААМАГЛАЛ
- 4 СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны зорилго

- Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны (2025-2035 он) эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгааг 2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ) болон судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК-ийн багтай хамтран гүйцэтгэсэн.
- Энэхүү шинжилгээний ажилд хөдөлмөрийн зах зээлийн таамаглал боловсруулах Эдийн засгийн загвар, Хүн ам зүйн шинжилгээ, Ажил мэргэжил-салбарын чиг хандлагын шинжилгээ зэрэг өмнөх судалгааны ажилд ашигласан арга, аргачлалыг ашиглан, суурь мэдээллийг уртасган, үр дүнг шинэчлэх ажлын 2024 онд гүйцэтгэлээ.


Өнөөгийн нөхцөл байдал

Ажиллах хүчний оролцооны түвшин, 1992-2023, хүйсээр




— Нийт — Эрэгтэй — Эмэгтэй
 ОУХБ (2023): Эрэгтэй 72%, эмэгтэй 47%
 Эх сурвалж: YCX, 1212.mn

Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлгээр, 2013, 2023 он



Эх сурвалж: YCX, 1212.mn


Ажилгүйдлийн түвшин, насны бүлгээр болон NEET түвшин



— Бүгд — 15-24 насны — 25-64 насны — 65 болон түүнээс дээш насны — ХЭББСХБ
 ОУХБ (2023): 20.4%
 Эх сурвалж: YCX, 1212.mn

Хөдөлмөрийн бүтээмж, 2023

Нэг цагийн хөдөлмөрийн бүтээмж буюу Ажилласан нэгж цагт ногдох гарц (GDP constant 2021 international \$ at PPP)	
Америкийн нэгдсэн улс	77.7
Австрали	67.8
Япон	53.1
Солонгос	45.4
Казакстан	36.8
Дэлхий	22.2
Зүүн Ази	21.2
Дундаас дээгүүр орлоготой орнууд	19.5
Монгол	17.5
Ази, Номхон далай	15.9
Дундаас доогуур орлоготой орнууд	9.4





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
 ИСТИТУТ

Хөдөлмөрийн орлогын өнөөгийн байдал

Цалингийн өсөлт

- Нэрлэсэн цалингийн өсөлт
- Ам.доллаар илэрхийлсэн цалингийн өсөлт
- Бодит цалингийн өсөлт



Он	Сарын дундаж цалин, мянган төгрөг	Сарын дундаж цалин, ам.доллар оор	Бодит цалингийн индекс (ХҮИ, 1995=100)
2000	62.3	57.9	28.4
2001	65.2	59.4	27.5
2002	71.3	64.2	29.6
2003	81.5	71.1	32.3
2004	93.	78.5	33.2
2005	101.2	84.0	33.0
2006	127.7	108.3	39.2
2007	173.	147.8	45.1
2008	274.2	235.1	58.6
2009	300.4	208.9	61.5
2010	341.5	251.8	61.9
2011	424.2	335.2	70.6
2012	557.6	410.2	81.4
2013	774.9	507.9	100.6
2014	796.6	438.1	93.2
2015	808.	410.0	92.7
2016	861.9	401.3	97.7
2017	944.5	387.0	100.6
2018	1,002.9	405.6	98.8
2019	1,124.3	422.0	105.2
2020	1,220.6	433.8	111.7
2021	1,279.4	449.0	102.9
2022	1,503.8	478.2	106.8
2023	1,881.8	543.0	123.8

ХЗЗ-ийн таамаглалыг боловсруулсан арга зүйн тойм

ШААРДЛАГАТАЙ АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ТААМАГЛАЛ

1. Эрэлтийн төсөөлөл буюу ДНБ-ий таамаглал

1.1. 1995-2023 оны бодит ДНБ-ий өгөгдөл → Тренд (HP filter) → Бодит ДНБ-ий таамаглал

1.2. ДНБ-ий дефляторын таамаглал → Нэрлэсэн ДНБ-ий таамаглал

1.3. Ам.долларын ханшны таамаглал → Ам.доллаар илэрхийлэгдсэн Бодит ба нэрлэсэн ДНБ

1.4. Хүн амын хэтийн тооцоо → Нэг хүнд ногдох ДНБ

1.5. ЭЗҮА салбаруудаарх ДНБ-ий таамаглал

1.6. Бүсүүдийн болон аймгуудын ДНБ-ийн тооцоо

2. Эрэлтийн буюу шаардлагатай ажиллагчдын тооны таамаглал

2.1. ДНБ-ий өсөлт болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин (ХЭТ)-ий хамаарлын шинжилгээ

2.2. ХЭТ-ий таамаглал

2.3. Хүн амын хэтийн тооцоо/хөдөлмөрийн насны хүн амын тоо

2.4. Шаардлагатай ажиллагчдын тооны таамаглал

2.5. Ажиллах хүчний судалгаа (АХС)-ны 2009-2023 оны үр дүнг ашиглан жил бүрийн салбар-ажил мэргэжлийн матрицыг гаргаж, гулсуулсан дундаж (moving average)-ийн засварлан трендийн матрицыг тооцсон. Уг матрицыг ашиглан:

- ISIC-ын 19 салбараар, YAMAT-08-ын 9 бүлгээр, 88 дэд салбараар, 43 ажил мэргэжлийн дэд бүлгээр шаардлагатай ажиллагчдын тоог 2024-2035 он хүртэл гаргасан.

ХӨДӨЛМӨРИЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТААМАГЛАЛ

1. Хөдөлмөрийн насны хүн амын тооцоо

2. АХОТ → Ажиллах хүчний таамаглал

3. Ажилгүйдлийн түвшин → Ажилгүй иргэдийн таамаглал


4. Ажиллагчдын тооны таамаглал

ДНБ, эдийн засгийн өсөлтийн таамаглал

Бодит ДНБ болон түүний трендийн утга




Бодит ДНБ-ий 2035 он хүртэлх таамаглалын утгууд, тэрбум ₮




Бодит ДНБ-ий таамаглал, 2015 оны үнээр

Улсын бодит ДНБ-ий өсөлт нь 2008-2009 оны дэлхийн эдийн засгийн хямрал болон 2020-2021 оны Ковид-19 цар тахлын нөлөөгөөр сөрөг утгатай гарч байсан. Харин урт хугацааны ирээдүйн трендийг тодорхойлохдоо завсрын ийм төрлийн шокууд гарахгүй хэмээн суурь нөхцөл тавьж өсөлтийн трендээр нь таамаглал хийсэн.




ХЗЗ-ийн эрэлтийн таамаглал

Хүн амын нас, хүйсийн суварга, 2022, 2025, 2030, 2035 он




Хүн ам зүйн ачаалал, хувиар




229 улс, бүс нутгийн сүүлийн 30 гаруй жилийн тоон өгөгдөл:

- Нэг хүнд ногдох ДНБ
- Хүн ам
- Залуусын ачаалал
- Өндөр настны ачаалал
- Хүйсийн харьцаа
- Голч нас

Бодит НХНДНБ, сая ₮




Бодит НХНДНБ, \$




■ Холимог трендээр ■ Квадрат трендээр

Хөдөлмөр эрхлэлтийн түвшний таамаглал







ДНБ өсөлтийг хангахад шаардлагатай ажиллагчдын тоо



Шаардлагатай ажиллагчдын тоо, ЭЗҮА-ны салбараар



ӨНГӨРСӨН ТРЕНДЭЭР
 Ө АЛСЫН ХАРАА 2050



■ Өнгөрсөн трендээр (ДНБ +4.5%)
■ Алсын Хараа 2050 (ДНБ +7.2%)












МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



ИНСТИТУТ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ
ᠵᠢᠰᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ
ᠶᠡᠨ ᠰᠢᠳᠤᠰᠡᠨ
ᠶᠡᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ

Шаардлагатай ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар



—■— Өнгөрсөн трендээр (ДНБ +4.5%)
—■— Алсын Хараа 2050 (ДНБ +7.2%)

Шаардлагатай ажиллагч, дэд ажил мэргэжлийн ангиллаар



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



ИНСТИТУТ

ᠰᠢᠨᠵᠡᠯᠡᠬᠡ ᠤᠬᠠᠨ
ᠶᠡᠯᠢᠨᠠᠵᠢᠯᠠᠭᠤᠨ
ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠢᠶᠢᠨ
ᠠᠨᠭᠢᠯᠠᠯᠠᠭᠤᠨ
ᠠᠵᠢᠯᠠᠭᠤᠨ

Дэд ажил мэргэжил		ДНБ квадрат трендээр өсөх үед 2025-2035 онд өсөх дүн	ДНБ холимог трендээр өсөх үед 2025-2035 онд өсөх дүн
SM30	‘Барилга, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан, цахилгаанч	37	40
SM24	‘Борлуулалтын ажилтан’	31	36
SM11	‘Бизнес, захиргааны мэргэжилтэн’	23	25
SM8	‘Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн’	22	24
SM23	‘Хувийн үйлчилгээний ажилтан’	21	24
SM37	‘Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч’	21	25
SM34	‘Хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл	19	21
SM10	‘Багшлах мэргэжилтэн’	17	20
SM4	‘Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал’	16	17
SM40	‘Уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил’	16	17

Салбар, ажил мэргэлийн ангилалаар ажиллагчдын тоог таамаглах нь:

- Дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувилбарт салбарын үндсэн ангиллаарх ажиллагчдын бүтцийг таамаглах
- 2009-2023 оны АХС-ы үр дүнгээс ажиллагчдын 88 дэд салбар, 43 дэд ажил, мэргэжлийн матрицыг тооцоолж, 15 жилийн дундаж бүтцийг гаргах
- Ажиллагчдын 19 салбарын бүтцийг 88 дэд бүлгүүдэд хуваан таамаглах
- Тус салбар бүрийн хувьд мэргэжлээрх бүтцэд задлах

ХЗЗ-ийн нийлүүлэлтийн таамаглал




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР




ИНСТИТУТ

ᠬᠤᠵᠡᠳᠡᠨ ᠨᠢᠶᠢᠯᠡᠭᠡᠯᠡᠲᠢ ᠲᠠᠮᠠᠭᠯᠠᠯ


Ажиллах хүчний оролцооны түвшний таамаглал




Ажиллах хүч



Ажиллах хүчний таамаглал, мянган хүн




Ажилгүйдлийн түвшний таамаглал




Ажилгүй иргэд




Ажилгүй иргэдийн таамаглал, мянган хүн



Ажиллагчдын тооны таамаглал, мянган хүн



Хөдөлмөрийн эрэлт ба нийлүүлэлтийн зөрүү



- АХОТ нь 2023 оны түвшинд хадгалах үед тухайн үед ажиллаж байх хүн
- Нэг хүнд ногдох ДНБ Квадрат трендээр өсөх үед шаардлагатай ажиллагчид
- Нэг хүнд ногдох ДНБ Холимог трендээр өсөх үед шаардлагатай ажиллагчид
- Квадрат трендээр өсөх үед нэмж нийлүүлэх шаардлагатай ажиллагчдын тоо
- Холимог трендээр өсөх үед нэмж нийлүүлэх шаардлагатай ажиллагчдын тоо

Нэмж нийлүүлэх шаардлагатай ажиллагчдын тоо = Шаардлагатай ажиллагчдын тоо (Эрэлт)* – Тухайн үед ажиллаж байх хүний тоо (Нийлүүлэлт)**

* ДНБ-ий зорилтыг хангах нөхцөлд

** АХОТ-ийг 2023 оны түвшин хадгалагдана, ажилгүйдлийн түвшнийг 5 орчим хувьд хадгалагдана гэдэг нөхцөлд

Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж

- Монгол Улсын ДНБ-ийг хэд хэдэн хувилбараар таамагласан. Тэдгээрээс Алсын Хараа 2050 урт хугацааны зорилтод хүрэх өсөлтийг хангаж (жилд дунджаар 7.2%-аар өснө) чадна гэвэл бодит ДНБ нь 2030 онд 49,719 тэрбум төгрөг, 2035 онд 70,509 тэрбум төгрөг (35,780 сая ам.доллар) болохоор таамаглагдаж байна.
- Энэ хэмжээний хурдан өсөлтийг хангахын тулд урт хугацааны зорилтыг ханган хурдацтай өснө гэвэл 2030 онд ХЗЗ дээр 1,624.6 мянган ажиллагч, 2035 онд 1,843.5 ажиллагч шаардлагатай юм.
- Хэрэв АХОТ-г 2023 оны түвшинд хадгалагдах, ажилгүйдлийн түвшнийг 5 орчим хувьд хадгалагдах нөхцөл тавьж тухайн үед хөдөлмөрийн зах зээл дээр ажиллаж байх ажиллагчдын тоог тооцвол 1,476 мянга, 2035 онд 1,624 мянга байна.
- Энэхүү эрэлт нийлүүлэлтийн зөрүүгээр 2030 онд 148 мянга, 2035 онд 220 мянга орчим ажиллагчийн хомсдолтой байх тооцоо гарч байна.

Хөдөлмөрийн зах зээл дээр үүсч буй эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг хэрхэн хангах вэ?

1. Ажилгүй иргэдийг хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх → Залуучуудын хөдөлмөр эрхлэлт → Ур чадвар, мэргэжил, боловсролын нийцэл
2. Ажиллах хүчнээс гадуурх, боломжит ажиллах хүчийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэх → Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт

Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж

- Энэхүү таамаглалд дурдсанчлан, 2025 онд 75-80 орчим, 2030 онд 85-90 орчим, 2035 онд 85-98 мянган ажилгүй иргэд байхаар таамаглагдаж байна.
- Өмнө дурдсанчлан, 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр байдаг. 2023 оны байдлаар 15 орчим мянга орчим залуус ажилгүй байна. Тэднийг шалтгаанаар харахад ажил хайгаад олдохгүй байгаа (36.6 хувь), мэргэжил, дадлага туршлага байхгүй (19.4 хувь) гэсэн шалтгаанууд зонхилж байна.
- Ажил хайгч болон ажил олгогч хоёрын нэгнээ олох процессыг дэмжих, хурдасгах, хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй.
- ИДС болон МБСБ төгсөгчид, залуучуудын олон судалгааны үр дүнгээс шинэ төгсөгчдийн ур чадвар нь ажил олгогчдын хайж буй ур чадвараас зөрүүтэй байдаг нь илэрдэг. Энэ үзэгдлийг бууруулах нэг арга нь дадлагыг үйлдвэрийн орчинд, чанартай хийлгэх, ажил олгогчидтой хамтран ажиллах явдал бөгөөд үүнийг олон судалгааны үр дүн, зөвлөмжүүдэд дурдсаар ирсэн.
- Мөн залуусын мэргэжил, сургууль сонголтыг оновчтой хийхэд шаардлагатай мэдээллийг түгээх, дэмжлэг үзүүлэх шаардлагатай.
- Ажиллах хүчний судалгааны 2010-2022 оны тоон өгөгдөлд тулгуурлан Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх боловсролын босоо болон хөндлөн зөрүүг тооцоход Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн нийт ажиллагчдын 8.5 хувь нь боловсролын илүүдэлтэй, 13.7 хувь нь боловсролын дутагдалтай байна. Боловсролын хөндлөн зөрүүг шинжлэхэд нийт ажиллагчдын 47% нь эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг, 53% нь мэргэжлийн зөрүүтэй байна. (Хөдөлмөрийн орлого ба боловсролын зөрүү, Б.Дуламзаяа, Д.Мядаг)
- Ур чадвар, мэргэжил болон боловсролын түвшний нийцэл нь ажиллагчдын бүтээмж өсгөх, өндөр цалин авах боломжийг бий болгодог.


Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж

- Эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг нөхөх өөр нэг хэсэг нь ажилгүй иргэдээс гадна, ажиллах хүчнээс гадуур байгаа, ажил хайж байгаа боловч одоогоор ажилд орох боломжгүй байгаа эсвэл ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой байгаа “боломжит ажиллах хүч” байна.
- 2023 оны байдлаар Боломжит ажиллах хүч: 39,841 байгаагаас 57.1 хувь нь (23 мянга) эмэгтэйчүүд, 42.9 хувь нь (17 мянга) эрэгтэйчүүд байна.
- Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог дэмжих, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн оролцооны зөрүүг бууруулах нь эдийн засгийн хувьд ихээхэн өгөөжтэй байдаг.
- Өрх гэр болон ажлын байран дахь жендерийн тэгш бус байдлыг арилгаснаар Монгол Улс эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцооны түвшнийг 63.2 хувь хүртэл өсгөх боломжтой. Ингэснээр нэг хүнд ногдох жилийн өсөлтийн түвшнийг 0.5 хувиар нэмэгдүүлж, 30 жилийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүнийг 16.1 хувиар өсгөх боломжтой. (“Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь-2020”, Азийн Хөгжлийн Банк)
- ХЗЗ дээр, бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийг асардаг эмэгтэйчүүдэд уян хатан цагаар ажиллах боломжийг олгох, тогтолцоог бүрдүүлэх,
- Ажил олгогч, аж ахуйн нэгж нь хүүхэд харах үйлчилгээ, газруудыг бий болгож эмэгтэйчүүдэд ээлтэй ажиллах орчныг бүрдүүлэх,
- Ийм нөхцөлийг бүрдүүлж, дэмжих бодлогыг хэрэгжүүлсэн ажил олгогч, аж ахуйн нэгжийг урамшуулах замаар ажлын байран дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх боломжтой. (Lime Mehtar, Yazan Jayyousi, Njood Gammoh, and Ahmad Al Haj, 2016)


АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

 www.institute.gov.mn

 info@institute.gov.mn

 Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, Нарны
зам, 55-р байр

 www.facebook.com/tarilsp

 (+976) 77001331